

ҮЙЛИЙН СУДАЛГАА МОНГОЛ СОЁЛЫН ГЕНИ СУДЛАЛ БОЛОХ НЬ

Б.Жадамба, академич, МУБИС

Abstract

The study aims at identifying the traditions of the concepts ‘action study’ and ‘action’, by investigating the philosophy derived from the shamanistic culture of Mongolian nomads. To achieve the aim, the study revises the research sources about shamanistic culture of Mongols, and then selects the concepts that can be considered as the gene of our traditional culture. In analyzing those concepts, the study has made the conclusion. Moreover, the study raises an idea that the concept “ingenuity (ingenuim)” as the gene of Mongolian traditional culture derived from the barbarous thinking of ancient people, is the term “action” to which we have recently given more significance. Having respectfully recognized the concept “ingenuity (ingenuim)” and analyzed the ingenuity of the occurrences in daily lives for their permanent existence, the Mongolian people have created their history and culture, for instance, the philosophy of “actions and results”, the worldview of “Eternal Heaven” and one world approach. The study concluded that these cultural elements can be considered as the pragmatic result of their learning through their living in a full harmony with nature while hunting and herding animals.

Түлхүүр үг

Соёлын гени, амь, амьдрал, нэг, амь ухаан, амьдралын ухаан, үйл судлал, үйлийн судалгаа, үйлийн явцдаа суралцахуй...

Судалгааны дизайн

Эртний монголчуудын бүтээсэн бөө мөргөлийн соёл бол монгол соёлын анхдагч төдийгүй өвөг нэгэн. Тэрхүү бөө мөргөлийн өвөг соёлын эши ухагдахуунууд бол монгол соёлын гени юм. Тиймийн учраас, өөрсдийнхөө соёлын генийг тодруулахын тулд, юуны өмнө бидэнд монгол бөө мөргөлийн соёл, түүний хүрээний гүн ухааныг авч шинжих хэрэгцээ шаардлага бий болсон.

Эл хэрэгцээ шаардлагын улмаас бид монгол бөө мөргөлийн соёлоос үүдэлтэй хоёрын дундаас гуравт дэвшдэг гурамсан сэтгэлгээ, хоёр эши харилцан шимэлцэх хууль, “амь, ахуй, ухамсар”-ын гурвал онол тэргүүтнийг тоймлон шинжилж, нүүдэлч монголчуудын соёлын гени, түүний тусламжтайгаар агуу түүх соёлоо бүтээсэн арга ухааныг тодруулан судалж, үр дүнг өнөөгийн судлаачдын анхаарлын төвд байгаа үйл, үйл судлал хэмээх ухагдахуунуудтай харьцуулж нэгтгэн дүгнэх нь энэхүү ажлын зорилго байлаа.

Зорилгодоо хүрэхийн тулд, бид эхлээд эртний монголчуудын онгон шүтлэг, өвөг монгол хэл, бэлгэ шүтлэг, овгийн эх үүсвэр, үлгэр домог, аман зохиол болон “Монголын нууц товчоо” зэрэг зарим бичмэл материалыг судлагдахуунаар \баримт болгон\ сонгож, тэдгээрийн хүрэн дэх амь ухагдахуун болон түүнийг тодорхойлж байсан арга ухааныг судалсан. Түүнийхээ үндсэн дээр амь, түүнд түшиглэсэн бүтээсэн өвөг соёлын цаана агуулагдаж буй арга зүйг тодруулан, тэдгээрийг үйл, үйл судлалын талаарх гадаадын эрдэмтдийн болон өөрсдийнхөө санаа бодолтой харьцуулан шинжиж, “Үйл бол монгол соёлын гени. Үйлийн судалгаа нь монгол соёлын гени судлал” гэсэн санаа дэвшүүлэн та бүхнээр хэлэлцүүлж буй болно. Хэдийгээр мөхөс миний бие бөө болон соёл судлаач биш боловч, тэдгээр салбарын эрдэмтдийн туурвисан бүтээлүүдийг өөрсдийн

сүүлийн жилүүдэд үйл судлалын чиглэлээр хийсэн судалгаа, түүний явцад бий болсон итгэл үнэмшлийнхээ үүднээс харж эл санааг дэвшүүлсэн билээ.

Судалгааны арга

Энэхүү ажилд судлагдахуун болох баримт материал дах судлах зүйлсийг ажиглах, тоймлох, цэгцлэх, задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, гурвалжаар шинжих, гурвалжаар баталгаажуулах, логик дүгнэлт хийх зэрэг судалгааны аргууд ашиглагдсан.

Үр дүн, түүний нотолгоо

Монголчуудын бөөгийн соёл хийгээд гүн ухааны талаарх эх сурвалжуудыг судалж шинжлэн, тэдгээрийн үндэс язгуур нь АМЬ хэмээх ухагдахуунд байна. Бөө мөргөлийн соёл, гүн ухаанд дэвсгэрлэж монголчуудын “үйл үр” – ийн прагматик гүн ухаан, “мөнх тэнгэр” үзэл, “нэг ертөнц” үүсэж хөгжсөн зэрэгт түшиглэн “АМЬ” ухагдахууныг монгол соёлын гени гэж хэлж болно. Тэрхүү монгол соёлын гени болох АМЬ ухагдахуун бол өнөөгийн бидний ихээр ярьж, бичиж, судалж буй ҮЙЛ байна. Өвөг дээдсийн маань бидэнд өвлүүлсэн агуу түүх соёлыг бүтээн хөгжүүлсэн арга технологи нь АМЬ болох ҮЙЛ судлал юм байна зэрэг санааг дэвшүүлсэн. Тэрхүү санаа тохироц сайтай, үнэн бодитой гэдгийг гурван өөр эх үүсвэрээс, гурван өөр аргаар, гурван өөр судлаачдын гурамсан багц баримтуудаар нотолсон болно. Үүнд:

Нэгэн зүйл: үйл нь нүүдэлч монголчуудын соёлын гени болох амь ухагдахуун юм.

Нотлох баримтын нэгдүгээр багц:

1. “Монголчуудын уламжлалт гүн ухаан ... ертөнцийн хамаг юмс үзэгдлийг бодат юм,

- оюун санаа хэмээн туйлын нэгэн утгаар ялган салгаж үздэггүй. Зөвхөн энэ хоёрын төгс зохицлыг илэрхийлэгч бэлгэдэл маягаар сэтгэсэн Амь ухагдахууныг нээсэн үнэн бий...(Н.Нагаанбуу, Монголчуудын Анх, Энх, Мөнхийн амин зурхай, Уб., 2009)”, “...эрэг сөрөг, идеал матери, арга билиг, инь ян зэрэг сөргөлдсөн хоёр ойлголтыг Монголчууд “амь” гэх ай\категори\ -гаар шүүн амилуулснаар гурвал ухаан бүрэлдэх нөхцөл үүджээ. (Н.Нагаанбуу, 2005, х.13)”,
2. “...ахуй ухамсарын ойлголт нэгэнт сансар тэнгэрт мандлаа хэмээн ойлгохоор энэ хоёрын ялгаа нэн тодорхой болж түүний зууч “амь” ухагдахуун болохыг зааж байдаг.... (Тү. Өлзий, 2011, х.252 – 253)”,
 3. “Үйлээр нийлж, үндсээр ургадаг”, “Хоёр уул хол боловч үүл манангаар нийлдэг, хоёр хүн хол боловч хэрэг явдлаар \үйлээр – Б.Ж\ нийлдэг” \монгол ардын зүйр үгс\”.

Нотлох баримтын хоёрдугаар багц:

1. “Амь гэдэг бол цаг хугацаа орон зайн эзэн амь – с – гал (Н.Нагаанбуу, 2005, х.28)”; “Амь бол хөдөлгөөн, үйл явдал, бас үнэн оршихуй гэж ойлгогдоно. Тэгвэл “амьгүй юм” худал аж. Эндээс амьгүй юм гэж үгүй гэсэн гаргалгаанд ч хүрч болно” (Тү. Өлзий, 2011, х.331),
1. “ҮЙЛ нь “орон –цаг”, бас алив бүхний өөрөө болсон ёс (Б.Жадамбаа, 2016)”; үйл – хийж бүтээж байгаа ажиллагаа \ажиллагаа – үйлийг хийх үйл, хөдөлгөөн, хөдлөх үйл, оёх,урлах зүйл, оёдол, хувь заяа, хувь төөрөг, зовлон (Б.Баярсайхан, 2009, х.742),
2. “...тэнгэр бол аливаад амь сүнс соёрхдог бөгөөд түүнийг туурвигч үйлийг заяа гэдэг...(Дорж Банзаров, 1999); “амь гэдэг хорвоогийн шалтгаан, амьдрал гэдэг нь ахуй хийгээд сэтгэлийн баримт, амьтан гэдэг ертөнцийн жишээ” (Н.Нагаанбуу, 2005, х.13); “...Эцэг эхээс заяасан энэ бие ба Илбэ мэт бодьгүй сэтгэл хоёр Эгэл зүгээр суухад ондоо мэт санагдавч Эрхэм хэргээ бүтээхэд НЭГИЙГ хүснэ...” (Д.Равжаа, “Нэгийг хүснэ” шүлэг).

Нотлох баримтын гуравдугаар багц:

1. “ҮЙЛ = “үйл үйл* = үйл – нэг = үйл – үйл* -нэг = үйл – амьдрал – нэг” \Б.Жадамбаа, 2016\”,
2. “АМЬ = “амь нэг = амь – нэг = амь – амьдрал -нэг” \дээр өгүүлсэн\”,
3. “Ертөнц “нэг амь” \”нэг бодгаль”\ хийгээд “амь нэг” \”бодгаль нэг”\ гэдгээс, АМЬ гэдэг бол “БОДГАЛЬ” юм. Тэр АМЬ болох БОДГАЛЬ = бодгаль нэг* = бодгаль - нэг* = бодгаль – нэг* - бодгаль** = “амь – амьдрал – нэг” гэсэн ҮЙЛ лугаа гурвал бүтэц бүхий нэгэн байна.

Нэгэн зүйл: Үйл судлалын прагматик тал болох “үйлийн явцдаа суралцахуй” бол эртний

Монголчуудын бөө мөргөлийн гүн ухааны бүтээн хөгжүүлсэн арга технологи байна.

Нотлох баримтын нэгдүгээр багц:

1. “Эртний хүн амийг айхтар дээдэлж байсны уламд түүний төлөө хийгдсэн бүх үйл ажиллагаа амийг танихаас эхэлсэн хэмээн үзүүштэй....Эртний хүн төрөлхтөн шүтээний утгаас амийг дээдэлж байснаас биш үхлийн утгаас амийг шүтсэн бус нь тодорхой. “Амь байснаас хүн байна” гэж сэтгэдэг учраас, бүх юмыг амин бүрэлдээ болгон шүтэж, цаашилбал, амь ба сүнс, амь ба бөө бол ахуй нөхцөлийн тэр үедээ нэг л утгаар ойлгогдож байсныг саналтай....” (Өлзий, 2011, х.236 -237).
2. “...Эртний хүмүүс амийг “шүтээний хэлбэр” болгож байсан нь маш сонирхолтой... Дүрсийг танихаас хүний ертөнцийн ухаан хөгжиж эхэлсэн нь үнэн байна...Эртний хүн өөрийн биеэ байгал цогц болгож...бие цогцдоо түшиглэн байгалын сүрхий үзэгдэл буюу гэнэтийн бололцоог таньж байжээ... (Тү. Өлзий, 2011, х.252–253)”, “Амь бол дүрсийн хэлбэр мөртөө дүрс бол амь биелэл мөн” \Тү. Өлзий, 2011, 63 дугаар тал\”
3. “Хүй нэгдлийн хүний сэтгэлгээ нь бүхэлдээ домог зүйн сэтгэлгээ байжээ....Хүй нэгдлийн хүний ухамсар бол дүр\дүрс\ -ээр сэтгэх сэтгэлгээ байжээ” (Дулам, 1989)

Нотлох баримтын хоёрдугаар багц:

1. “Нүүдэлчин түмэн бол амь ахуйн \экологийн\ тэнцүүрийн эзэн юм. “Амь, ахуй, ухамсар” бол малчин ардын гүн ухааны сэтгэлгээ үнэхээр мөн болно. Явцууруулж хэлбэл нүүдэлчид бол бөө мөргөлийн гүн ухаантай ард түмэн байлаа....Малчин ардын гүн ухаан нь таван хошуу малтайгаа байнгын шүтэлцээнээсээ эх байгалийн хатуу ширүүн шалгарлын хуулиар эх байгалиа хамгаалах явцад гүн ухааны үндсэн эх төлөв нь бүрэлдсэн. Тиймээс эх байгалийн тухай гүн ухаан болно. Тодруулж хэлбэл, амь ахуйн \экологийн\ гүн ухаан юм” (Өлзий, 2011, х.273),
2. “Монгол ардын гүн ухааны анхдагч нь “амьдрахуй ухаан”. Мал маллах, түүний аясаар бэлчээр даган цагийн дөрвөн улиралд нүүдэллэн аж төрж ирсэн нь малчин нүүдэлчин хүмүүсийн оюун санаанд амьдрахуйн арга ухааныг бүрдүүлсэн (П.Хорлоо, Монгол аман зохиол дахь ардын гүн ухааны сэтгэлгээ”, Үндэсний хэвлэлийн хороо, 2002)
3. “Дээр хөх тэнгэр, доор бараан дэлхий үүдсэний завсарт хүний хөвүүн буюу. Ертөнцийн оршихуй-арга хийгээд билгийн зайлшгүй чанарыг заяа тавилан, жам ёс, орчлонгийн зүй, хүмүүний ёсон хэмээн үзэж асан ажээ. Ертөнцийн хэмнэлт хэм хэмжээ хуулийг тусгасан, тэгэхдээ байгалыг хүнчлэн \эсвэл хүнийг байгальчлан\

сэтгэсний үр дүн болох учир хүний тэнгэрт шүтэхүй бишрэхүй нь аливаа үйл үйлдлээн түүнд сохроор даатгасан хэрэг биш харин ч байгаль лугаа зохицон амьдрахуй хэрэгцээг оюун сэтгэлгээний харьцангуй өндөр төвшинд боловсруулсны баримт нэгдэл, эрхшээл дэх байгаль – хүн – хүний харилцааг тэгш агуулдаг болно. (Монголын философийн түүх, „1997”).

Нэгэн зүйл: Үйл, үйл судлал нь монголчуудын соёлын тулгуур ухагдахуун буюу гени болох амь, амь судлалын эдүгээчилсэн томъёолол байна.

Нотлох баримтын багц:

1. “Бөө мөргөлийн шашин буй болсон нь бусад шашин суртахуунаар шалтгаалсан биш, бас ч дан ганц увдисын илрэл бус, харин хүмүүсийн аж амьдрал ба эх байгалийн тухай тайлбар. Энэ тайлбарт бөө мөргөлийн түүхэн явц, үүсвэр бодос чигийг юунаас ирэх вэ гэдэг асуудлыг “аж амьдрал ба эх байгаль” –ийн оюуны зууч ухагдахуун “хүмүүн”-ээр “амь” -иар, Б.Ж\ төвлөх гүн ухаанлаг ёсыг яг угаас нь хөндсөн байна” (Дорж Банзаров, 1997)
2. Мөнх Тэнгэр үзэл дэх “дүр” бол “Мөнх Тэнгэр” ба Хаан” хоёрыг холбогч, зуучлагч АМБ ухагдахуун юм. Эл байдал, “Мөнх Тэнгэрийн хүчин – дүр, Хааны суу залийн ивээл – дүр” (Ш.Бира, 1999) гэсэн Мөнх Тэнгэр үзлийн “Мөнх Тэнгэрийн хүчин – дүр – Хааны суу залийн ивээл” (Б.Жадамба, 2009) томъёоллоос харагдаж байна. Учир нь, нэгд, “дүр” нь “Мөнх Тэнгэрийн хүчин” ба “Хааны суу залийн ивээл” -ийг, “Мөнх Тэнгэр” ба “Хаан”- ыг \хүмүүнийг\, хүмүүний гадаад ба дотоод эрчим хүчийг зуучлагч, холбогч ухагдахуун, хоёрт, дүр бол амины буюу “амь нэг” –ийн зогсонги, үзэгдэл, илрэл тал, гуравт, “Мөнх Тэнгэрийн хүчин” –г “ахуй”, “дүр”-ийг “амь”, “Хааны суу залийн ивээл” –ийг “ухамсар” хэмээн төсөөлбөл, тэр эртний монголчуудын бөө мөргөлийн соёлоос улбаатай “ахуй – амь – ухамсар” гэсэн гурвал онол лугаа болж байгаа зэрэгт оршиж байна.
3. Монголчуудын “үйл үр”-ийн прагматик гүн ухаан нь “ҮЙЛ”-ийн, “АМБ”-ны, “АМБДРАЛ”-ын тухай сургаал номлолын цогц юм. Учир нь, нэгд, ҮЙЛ \АМБ\ нь “үйл үйл*” \”амь амь*” = “үйл үр” \”амь амьдрал” \ = “үйл нэг” \”амь нэг”\ гэсэн бүтэц бүхий байдаг, хоёрт, “үйл үр” бол “амь амьдрал” учир, түүний тухай гүн ухааныг “амь амьдрал”-ын гүн ухаан хэмээж болно, гуравт, АМБ нь “үйл” ба “үр”-ийг холбогч нэгэн буюу “үйл үр” тул, “үйл үр” –ийн прагматик гүн ухааныг “АМБ”-ны тухай пагматик гүн ухаан юм зэрэгт оршиж байна.
4. Нэг ертөнцийн хандлага нь эртний монголчуудын бөө мөргөлийн соёлоос улбаатай амины тухай буюу амьдрахуйн

гүн ухааны нэгэн томъёолол төдийгүй түүний тулгуур ухагдахуун нь АМБ байна. Ингэж хэлсний учир нь, нэгд, нэг ертөнцийн хандлагад ертөнцийг мөн чанар талаас нь “нэг амь” \”нэг бодгаль”\, үзэгдэл талаас нь “амь нэг” \”бодгаль нэг*”\ хэмээдэг. Хоёрт, “нэг амь” болох “нэг бодгаль*” нь “нэг – бод* – бодь*” гэсэн “амь – ахуй – ухамсар” лугаа гурвал бүтэцтэй. Гуравт, “амь нэг” болох “бодгаль нэг*” нь “бод – бодь – нэг*” гэсэн “бие – амь – ухамсар” гэсэн мөн л “ахуй – амь – ухамсар” лугаа гурвал бүтэцтэй зэрэгт оршин буй болно.

Нэгэн зүйл: Эртний монголчуудын бөө мөргөлийн уг ёс \шаманизм буюу бөөизм х.48-49) буюу сургаал нь өнөө цагийн үйл судлалын нэгэн орчил лугаа хэсэгтэй байна. Энэ санаа нь дараах тайлбар болон баримтуудаас үүдсэн болно. Бөө мөргөлийн уг ёс бол эртний монголчуудын соёл сэтгэхүйн нэгэн ололт. Тэр манж- тунгас хэлний “шама-сэтгэл хөдлөн агсамнах (Өлзий, 2011), буюу хөгсөж бүжиглэх (Вальтер Хейсиг, 1998)”, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1998 он гэсэн утга бүхий үг ба “низм-сургаал, үзэл, уг ёс” гэсэн угтвар холбоо үгийн нэгсэл нэгэн. “Хөгсөж бүжиглэх” бол үйл. Уг үйлийн төрж бүтэж байгаа ажиллагаа болох өөрчлөгдөн нийлэлцэхүй нь “хөгсөх” бол, төрүүлж бүтээж байгаа ажиллагаа болох өөрчлөн нэгсүүлэхүй нь “бүжиглэх” юм (Жадамба, 2016). Үүнээс “хөгсөж бүжиглэх” нь “өөрчлөгдөн нийлэлцэхүй- үйл- өөрчлөн нэгсүүлэхүй” гэсэн бүтэц бүхий нэгэн гэж харагдаж байна.

Эл бүтцийн эхний бүрдүүлбэр болох “өөрчлөгдөн нийлэлцэхүй” бол хүмүүн ба байгалийн өөр өөрийнхөөрөө өөрсдөө аяндаа хувирч нэгсэхүй. “Өөрчлөгдөн нийлэлцэхүй” гэдэг нь хүн байгалийн доод агуу нэгдлийн үе дэх өөрсдийгөө судлагдахуун болгон байж, танихыг зорьж байсан эртний монголчуудын дотоод үйл \ далд ухамсарлал буюу ид\ Тэр өөрчлөгдөхүй ба нийлэлцэхүйн, бас сэтгэлийн ба санааны үйлийн нэгсэл нэгэн. Сэтгэлийн үйл \өөрчлөгдөхүй\ бол хүмүүний дотоод ертөнцөд төрсөн үйл хийх сэдэл. Тэрхүү сэдлээс санааны \хүмүүний бие, хэлний үйлдэх\ үйл \нийлэлцэхүй\ бий болдог, төлөвлөгддөг. Иймийн учир, “өөрчлөгдөн нийлэлцэхүй” -г “төлөвлөхүй” хэмээн ойлгож болно.

Дээрх бүтцийн хоёр дахь бүрдүүлбэр болох “үйл” бол хүмүүний дотоод ертөнцөд бий болсон санааны буюу бие, хэлний үйлдэх үйлийн хэрэгжилт, явц. Үйлдэх үйлийн хэрэгжилт, явц гэдэг бол хүмүүн ба байгалийн, хүмүүний дотоод ертөнц ба онгодын ертөнцийн харилцахуйг, төгс зохицлыг бий болгохуй юм. Тэрхүү харилцахуйн, төгс зохицлыг бий болгохуйн үр дүн нь “өөрчлөн нэгсүүлэхүй”. “Өөрчлөн нэгсүүлэхүй” бол бөөлөх үйлийн гурамсан холбооны гурав дахь бүрдүүлбэр. Үүгээр бөөлөхүйн \”хөгсөж бүжиглэхүй”-н \ нэгэн орчил өндөрлөдөг.

“Өөрчлөн нэгсүүлэхүй” нь “өөрчлөхүй” ба “нэгсүүлэхүй” -н нэгсэл нэгэн. Үүний өөрчлөхүй нь хүмүүн санааны үйл \үйлдэх үйл\ болох төлөвлөхүйгээ хэрэгжүүлснээр байгальд, онгодын ертөнцөд буй болсон зүйл. Энэхүү зүйлийг хүлээн авч, хүмүүн өөрийнхөө дотоод ертөнц ба онгодын ертөнцийн нэгдлийнхээ нэгэн шинэ “нэг”-ийг үүсгэж байгаа үйл юм. Энэ нь үр дүн болох “өөрчлөн нэгсүүлэхүй” бол онгодын ертөнцөд буй болсон зүйлийн ачаар хүмүүн дотоод ертөнцдөө нэгэн шинэ “нэг” \”дүрс”\ үүсгэхүй. Хүмүүнд шинэ баримт цугларахуй, бий болохуй. Хүмүүний онгодын ертөнцөд бий болсон зүйлийн талаарх баримт цуглуулахуй гэсэн үг.

Эдгээрийг базан, бөөлөхүй болох хөгсөж бүжиглэхүй нь “өөрчлөгдөн нэгсэхүй-үйл-өөрчлөн нэгсүүлэхүй” гэсэн гурвал бүтэц бүхий нэгэн. “Өөрчлөгдөн нэгсэхүй”-г “төлөвлөхүй”, “үйл” -ийг төлөвлөхүйн хэрэгжилт буюу явц, “өөрчлөн нэгсүүлэхүй”-г онгодын ертөнцөд бий болсон зүйлийн талаарх баримт цуглуулахуй хэмээн үзэх аваас, бөөлөхүйг \хөгсөж бүжиглэхүйг\ “төлөвлөхүй-үйл-үр дүнгийн талаарх баримт цуглуулахуй” гэсэн бүтэц бүхий эртний монголчуудын дотоод ертөнц ба онгодын ертөнцийн төгс зохицлыг шинээр илрүүлэх гэсэн нэгэн төрлийн арга технологи байжээ гэсэн санаа төрж байна.

- ... “шама”-гийн талаарх эрдэмтдийн тулгуур хэллэг болох “сэтгэл хөдлөн агсамнах” гэдгийг ...бүтэц шинжлэлээс задлавал “сэтгэл-санаа, хөдлөн-дүр, агсамнах-зорилго”-тойгоор юмс үзэгдлийг нэгэн цогцоор тодорхойлж, дотоодын санаа нь юунаас болох \сэтгэл\, юуг хийх \хөдлөн\, яагаад \агсамнах\ гэх маш эртний нийлэг ухамсарыг хадгалжээ. ...Үүнийг бөө мөргөлийн соёл сэтгэхүйгээс эрвэл “сэтгэл санаа” үүсэх гэдэг явдал анхны ухагдахуун болох ажээ...”Шама”-ны “хөдлөх –дүр” даруй “юуг хийхэд” шилжсэн бөөгийн бөөлөл хөдөлгөөн дүр”,, “юуг хийх” явц болох юм. “Шама”-ны “агсамнах-зорилго” нь даруй “юунд зориулсан” тэр мөртлөө “сэтгэл хөдлөл”-ийн оргилын шат онгод болох юм. Энд эртний хүмүүсийн “хурьцал шүтлэг” нь “агсамнах” дүр ажиллагаанаас “удган, бөө”гийн хурьцлаар нэгэн удганы эртний “андгай бүжиг”-ийн зорилго ингэж оргилдоо хүрдэг байжээ (Тү.Өлзий, 2011, х.52 -54)
- “...Чухам иймээс, бөөгийн аливаа зан үйл бол хүний ертөнц онгодын ертөнц хоёрын хоорондын өнгө харилцааны урлаг түүнийг дүрсэлсэн бэлгэдэлт наадам юм (Дулам, 2001) хэмээн эрдэмтэн Амивон өгүүлжээ.

Үүнийг Английн судлаач Курт Левин “үйл судлал бол нийгмийн үйлийн янз бүрийн хэлбэрийн нөхцөл хийгээд нөлөө дээрх харьцуулсан судалгаа, мөн төлөвлөхүй, үйл, үйлийн үр дүнгийн тухай баримт цуглуулах гэсэн орчил бүхий икл үе шаттай спиралийг ашиглан нийгмийн үйлийг оройлон тэргүүлэх судалгаа (Kurt Lewin, 1946, Action Research in Minority Problems)” гэсэн тодорхойлолттой жишин мөхөс миний бие “эртний монголчуудын бөө мөргөлийн уг ёс нь үйл судлалын, тухайлбал, түүний прагматик тал болох үйлийн явцдаа суралцахуйн өвөг хувилбар” гэсэн таамнал санааг дэвшүүлж буй болно.

Энэхүү таамнал санаа төрсний өөр нэгэн эх үүсвэр бол Өвөр монголын эрдэмтэн Тү. Өлзийгийн бөө судлалын талаар дэвшүүлсэн санаануудын багц байлаа. Тэрбээр

- “Монгол зан үйлийн нэвтэрхий толь” \оюуны боть\ -ийн “ардын шүтээн” –ий бүлэгт “манж –тунгус” хэлэнд бөөгийн сама \сэтгэл хөдлөн агсамнах гэсэн утгатай\ гэдэг учраас дэлхий нийтэд бөөгийн шашныг \саманы шүтлэг\ гэж хэлдэг. ...Эрдэмтэд үүнийг сонгодог тулгуур хэллэг гэж үзэцгээж байна “Низм” \nism\ бол угтвар холбоо үг болж “сургаал”, “үзэл”, “уг ёс”...зэрэг утгыг илтгэдэг.... (Тү. Өлзий, 2011, х.48 -49)”

- Мөн бөөгийн үйлийн “Идуган, бөөгөөс ирэх амь оршихуйн эрчим хүч” мөн (Өлзий, 2011, х.54)” гэж бөөгийн сургаал, түүний бүтэц бүрдүүлбэрийг тодорхойлжээ.

Хэлэлцүүлэг

Ертөнцийг нэг талаас, хамаг бүгдийн салах аргагүйгээр амьсан сүлбэлдсэн нэг амь буюу нэг амин нэгдэл (Б.Жадамбаа, 2010), нөгөө талаас, ертөнц нь нэг \нэг бодгаль*¹\ хийгээд бодгаль \бодгаль нэг*² (Б.Жадамбаа, 2013) хэмээн оюуны мэлмий нь нээгдэх үеэсээ л ухаарч, ертөнцийг нэвт танисан ард түмний нэг бол монголчууд билээ. Нэг бол ертөнцийн мөн чанар \бие\, бодгаль бол “нэг” –ийн “дүр” буюу ертөнцийн үзэгдэл \хэрэглэл\ тал. Нэгд бодгаль өвөрлөгдсөн байдаг бол, бодгальд нэг хурсан байдаг. Өөрөөр хэлбэл, нэг, бодгаль хоёр нь харилцан бие биеэ өвөрлөсөн байдаг. Нэг, бодгаль нь хоёр атлаа нэгэн, нэгэн атлаа хоёр бөгөөд харилцан бие, хэрэглэлийн холбоотой зүйлс. Нэг ба бодгаль бол ертөнцийг тэдгээрийн нэгдэлд нь, бие \нэг\ ба хэрэглэл \бодгаль\ талаас нь нэгэн утгатай төлөөлж, ба илэрхийлж чаддаг ухагдахуунууд. Тухайлбал, ертөнцийг нэг ба бодгалийн нэгдэлд бие талаас нь “нэг бодгаль” \”нэг”\, хэрэглэл \талаас нь “бодгаль нэг*” хэмээн үзэж болно³.

¹Нэг юм, нэг олон.

²Юм нэг, олон нэг.

³Нэг* – нэгийн эсрэгцэл буюу дүр, бодгаль* – бодгалийн эсрэгцэл буюу дүр, мөн нэгийн дүрс.

Энэ бол нүүдэлч монголчуудын гүн ухааны эдүгээчилсэн нэгэн хувилбар болох нэг ертөнцийн хандлагын томьёолол юм (Жадамбаа, 2009).

Хүмүүн, тухайлбал, монгол хүмүүн болох “бодгаль” анх үүсэхэд түүнтэй хамт, түүний дэргэд “нэг” болох “байгаль” л байсан. Тийм ч учраас тэд ертөнцийг байгаль ба хүний нэгдэлд нь байгаль талаас “байгаль хүн” \байгальчилагдсан хүн, нэг бодгаль*\, хүмүүн талаас “хүн байгал” \хүнчлэгдсэн байгал, бодгаль нэг*\ гэж эн сацуугаар төсөөлж байсан. Ертөнцийн “нэг бодгаль*” буюу “байгаль хүн”-ий төсөөлөлд бие буюу судлагдахуун нь “байгаль” бол, “бодгаль нэг*” буюу “хүн байгал”-ын⁴ төсөөлөлд бие буюу судлагдахуун нь “хүн” юм.

Анх ертөнц “нэг” байсан. Бүхий л зүйл, тухайлбал, хүмүүний өвөг болон анхны хүмүүс цөм байгальд өвөрлөгдсөн байв. “Нэг бодгаль*” бол энэ үеийн ертөнц. Үүний бодгаль*” нь “бодгаль* нэг***” юм. Тэгэхээр ертөнцийг “нэг – бодгаль* – нэг***” гэж төсөөлж болно⁵. Үүний “нэг” нь ертөнцийн мөн чанар, бас байгаль, бас тэнгэр. “Бодгаль*” нь амьтан. “Нэг***” нь дүрс. Энэ нь эл үеийн ертөнцийн төсөөлөл бол “нэг – амьтан-дүрс”, “байгаль – амьтан – дүрс”, “тэнгэр – амьтан – дүрс” гэсэн үг.

Тэгээд оюунт хүмүүн үүссэнээр ертөнц “хоёр болсон. Тэр “хоёр” нь байгаль ба хүмүүн. Тэгээд бүгд нийлээд гурав болсон. Энэхүү гурав хүмүүнд өвөрлөгдсөн байгаль болох “бодгаль нэг*”-ийн талаас бол “бодгаль-нэг*-бодгаль***” юм. Хэрвээ “бодгаль” нь хүмүүн, нэг* нь амь, тэнгэр, амьдрал, бодгаль** нь дүрс, газар гэдгийг тооцвол, “бодгаль- нэг*бодгаль***” нь “хүмүүн” төвт “хүмүүн-тэнгэр-газар”, “хүмүүн-амь-дүрс”, “хүмүүн-тэнгэр-дүрс”, “хүмүүн-амьдрал-дүрс” болно Энэ нь ертөнцийг аль ч талаас нь харсан, тэр гурвал бүтэц бүхий гурамсан холбоот нэгэн байна гэсэн үг. Эдгээр нь монголчууд бүтээсэн гурвал онолын (Н.Нагаанбуу, 2005) томьёололын анхдагч хувилбарууд юм. Учир нь, эртний монголчууд ертөнцийг амьтан хийгээд дүрсээр төсөөлдөг байсан. Нэг ертөнцийн хандлагын үүднээс хамаг бүхийг, тухайлбал, тэнгэрийг, газрыг, хүнийг “нэг”-ээр төсөөлж болдог (Б.Жадамбаа, 2010). БИ буюу ТА байгаагийн улмаас л ертөнц байна хэмээн үзэж болдог зэрэгтэй холбоотой билээ. Харин “бодгаль нэг*”-ийн “бодгаль-нэг*-бодгаль***” бол ертөнцийн талаарх “хүмүүн” \“бодгаль”\ төвт “хүмүүн-амьдрал-байгал”, “бодгаль-амьдрал-байгал” гэсэн монголчуудын гурвал онолын томьёололын хувилбарууд юм.

Эдгээрээс, монголчууд нэгд, аливааг “нэг”-ээр, “нэг*”-ээр \”дүр”-ээр\, “нэг***” -ээр \”дүрс”-ээр\ төсөөлдөг, *хоёрт*, хүмүүн \бодгаль\ бол тэнгэр ба газрыг нэгсгэгч болох нэг ертөнцийн амин сүнс \АМЬ\, гуравт, хамаг бүхий \бодгаль нэг\, тодруулбал, хүмүүн ертөнцийг нэгэн утгатай төлөөлж чаддаг, дөрөвт, эртний монголчууд анхандаа ертөнцийг амь болох “нэг” ээр, “амьтан” – аар, “дүрс”- ээр төсөөлдөг байсан, тавд, хүмүүн ба байгал \байгаль*\ хоёрыг нэгсгэгч “нэг*” бол “амьдрал” гэж тус тус илэрч байна.

Эл бүхнийг мэдэрсэн монголчууд нэг ертөнцийн судлагдахуунаар байгалийг \нэг бодгалийг\ биш хүнийг \бодгаль нэгийг\ сонгон, амийг айхтвар дээдэлж, түүнийгээ мөнх байлгахын төлөө бүхий үйл ажиллагаагаа зориулан оюуныхаа мэлмийг нээсэн түмэн. Судлагдахуун болох нэг ертөнцийг төлөөлөгч хүмүүн буюу “бодгаль нэг*” нь “бод⁶ – бодь⁷ – нэг*” гэсэн гурвал бүтэц бүхий нэгэн. Үүний бод нь хүмүүний “бие” буюу “махбод”\ хүмүүн\, Нэг* нь хүмүүнд хурсан нэг \ухамсар\, хүмүүний мөн чанар \байгал\, Бодь нь хүмүүн бие ба хүмүүний мөн чанар болох “нэг”-ийг \байгалыг\ эвлэлдүүлэн нэг буюу хүн болгон амилуулж буй зүйл буюу хүмүүний “амь” юм. Иймд хүмүүнийг “бие-амь-ухамсар”, “хүмүүн-амь-байгал” гэсэн гурвал бүтэц бүхий нэгэн гэж үзэж болно. Үүнийг мөн амины зогсонги тал нь амьдрал гэдгийг тооцон “хүмүүн-амьдрал-байгал” хэмээн томьёолж болно. Энэ бүхэн бол эртний монголчуудын бүтээсэн, нэг ертөнцийн, мөн амь амьдралын, амины, амьдралын тухай гурвал онолын хувилбарууд юм.

Нэг ертөнцийн хандлага, гурвал онол нь эртний монголчуудын бөө мөргөлийн соёл үүсч эхэлсэн үеэс бүрэлдэн хөгжжээ. Эртний гэдэг нь байгаль ба хүмүүний агуу их нэгдлийн буюу “ертөнц нэг” байх үеийн монголчууд юм. Тэр үед тэд ертөнцийг “нэг” л зүйлээр, тухайлбал, “нэг бодгаль*”-иар “нэг бодгаль*-нэг-бодгаль*”, эсвэл “бодгаль нэг*”-ээр “бодгаль нэг*-бодгаль-нэг*” гэж төсөөлдөг байжээ. Тэгэхдээ тэд “нэг бодгаль*-нэг-бодгаль*”-ийн “нэг бодгаль*”-ийг “амьдрал”, “нэг”-ийг “байгаль”, “бодгаль*”-ийг “амьтан”, “бодгаль нэг* -бодгаль-нэг*”-ийн “бодгаль нэг*”-ийг “амь”, “бодгаль”-ийг “хүмүүн”, “нэг*”-ийг “байгал” хэмээн тус тус үзэж байсан байна. Өөрөөр хэлбэл, нэг ертөнцийг “нэг бодгаль*” \”байгалыг өвөрлөгдсөн амьтан”\ талаас нь “амьдрал-байгаль-амьтан”, “бодгаль нэг*” \”хүмүүнд хурсан байгаль”\ талаас нь “амь-хүмүүн-байгал” \”амь-байгал-хүмүүн”\ хэмээн төсөөлж байжээ.

⁴Байгал – байгалийн эсрэгцэл \байгаль*\ болох байгал буюу жинхэнэ бодот байгал.

⁵Энд буй “нэг***”, “бодгаль***” бол харгалзан “нэг”-ийн “дүр” болох “нэг*”-ийн “дүрс”, “бодгаль”-ийн “дүр” болох “бодгаль*”-ийн “дүрс” болно.

⁶Бод-адуу, тэмээ, үхрийн ерөнхий нэр; бие, бодос, махбод\ус, гал, мод, төмөр, шороон махбод\ ; том будаа; шатрын бод.

⁷Бодь-удамбарын төрөл хар өнгийн хальстай, өндгөн хэлбэрийн том навчтай, нарийн голт мөнх ногоон мод, үнэнийг ухамсарлах онол, билиг, оюун санаа; нигүүлсэнгүй сэтгэл, ариун цагаан, амьдралгүй, хар хоргүй; бодь мөр-бурхан болохын зам мөр буюу ёс, бодь сэтгэл – ариун санаа амьдралгүй сэтгэл, “бодийг нь хөглөх”-амь насыг нь хөнөөх, ямар нэгэн юмыг эвдэж хэмхлэх; бод гөрөөс-гахайтай төстэй, хамар дээрээ бяцхан эвэртэй гөрөөс; зээр шиг биетэй, ямаан хоншоортой, ар зоо нь бор шарга толботой, өвчүүгээ дагаад урт цагаан өнгөтэй ширүүн үстэй, нарийн хар эвэртэй гөрөөс.

Эдгээрийг нэгтгэвэл, эртний монголчууд ертөнцийг “амь \амьдрал\ - байгал \байгаль\ - хүмүүн \амьтан\” гэж төсөөлж байсан нь харагдаж байна. “Амьдрал-байгаль-амьтан”, “амь-байгал-хүмүүн” бол харгалзан эртний монголчуудын бүтээсэн ертөнцийн талаарх “байгаль” \”нэг\” төвт “Амьдрал, Байгаль, Амьтан”-ы, “хүмүүн” \”бодгаль\” төвт “Амь, Байгал, Хүмүүн”-ий гурвал онолын томьёолууд юм. Хэрвээ “хүмүүн” \”бодгаль\” төвт “амь-байгал -хүмүүн” гурвалын “байгал”, “хүмүүн” нь “нэг бодгаль”-ийн “нэг” -ийн (Б.Жадамба, 2017) түвшинд харгалзан “ахуй”, “ухамсар” болохыг тооцвол, тэр “амь-ахуй-ухамсар” хэлбэртэй болно. Энэ бол судлаач Н. Нагаанбуугийн дэвшүүлсэн монголчуудын “Амь, Ахуй, Ухамсар”-ын гурвал онолын томьёолол юм (Н.Нагаанбуу, 1999).

Хүн бий болохоос өмнө “нэг” буюу “нэг бодгаль”, эсвэл “амьдрал-байгаль-амьтан” байж, түүнээс хүмүүн үүссэн болохыг “Монголын нууц товчоо”-нд “Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан Халдуун нутаглаж бүхүйд төрсөн Батачихан ажгуу” хэмээн томьёолсон байдаг.

Ертөнц бол нэг агаад бодгаль. Нэг бол ертөнцийн мөн чанар \бие\ тал. Бодгаль нь нэгийн үзэгдэл \хэрэглэл\ тал. Хүмүүн ч нэг ертөнц, байгаль ч нэг ертөнц. Хүн, байгаль хоёр ертөнцийг нэгэн утгатайгаар эн сацуу илэрхийлдэг. Хүн ба байгаль харилцан бие биеэ өвөрлөсөн байдаг. Өөрийн биеийг буюу “нэг” болох өөрийгөө ухаарч мэдвээс өөр бусдыг буюу өрөөлүүд болох “нэг”-үүдийг тольдож чадна. Би болох “нэг” байснаас ертөнц байна. Амь байснаас би буюу би болох нэг байна. Амь бол хүмүүн ба байгалыг эвлэлдүүлэн нэгсгэгч нэгэн буюу нэг зэрэг зөн совингууд бол монголчуудын бөө мөргөлийн гүн ухааны үндэслэлүүд юм. Эдгээр үндэслэлүүд нь тэднийг өөрөө болох биеэ буюу “нэг”-ээ ихээр дээдлэн судлагдахуунаар сонгож, өөрийнхөө амиа үлэмж чухалчлан, түүнийг танин мэдэж, мөнх байлгахын төлөө бүхий л үйл ажиллагаагаа зориулдаг болгожээ. Түүнийхээ ачаар л, тэд өөрсдийн бөө мөргөлийн гүн ухаан, түүнээс улбаатай соёлыг бүтээн үр ач бидэндээ өвлүүлэн үлдээсэн юм.

Бөө мөргөлийн \харын\ гүн ухаан бол монголчуудын соёлын анхдагч, Тэр гүн ухаанаас улбаатай бөө мөргөлийн соёл бол монголчуудын соёлын анхдагч. Тэрхүү бөө мөргөлийн соёлын, гүн ухааны тулгуур нь “нэг” хийгээд “амь” гэсэн хоёр ухагдахуун. Өөрөөр хэлбэл, нэг” хийгээд “амь” ухагдахуунууд нь монголчуудын бөө мөргөлийн соёлын, гүн ухааны хоёр эши, хос эхлэл юм. Иймийн учир, бид “нэг”, “амь” гэсэн хоёр ухагдахууныг монголчуудын соёлын, гүн ухааны “гени” төдийгүй тэдгээрийн хоёр эши, мөн хос эхлэл гэж үзэж байгаа болно.

Эртний монголчуудын бүтээн хөгжүүлсэн бөө мөргөлийн гүн ухаан тэдний өөрсдийнхөө, тодотгон хэлбэл, ертөнцийн үүсэл хөгжлийн

гүн нарийныг нэг ертөнцийн хандлагын дагуу “хүнчлэгдсэн байгал”, “хүн байгал”, “бодгаль нэг*” загвар, тэдгээрийн хүрэн дэх “амь-хүмүүн-байгал”, “амь хүмүүн-байгал” буюу “хүмүүн-амь-байгал”, “хүмүүн амь –байгал” гэсэн өөрсдийн дээдлэн шүтдэг “амь” ухагдахуунд түшиглэсэн гурамсан сэтгэлгээнийхээ үүднээс тодруулсан тайлбаруудын цогц нэгэн.

Энэхүү эртний хүмүүс өөрсдийгөө “амь хүмүүн-байгал” буюу “хүмүүн амь-байгал” цогц болгон авч, өөрсдийгөө болон байгалийг таньж мэдсэн гурамсан сэтгэлгээ нь анхлан “амь”-ийг “шүтээн” хэлбэрээр төсөөлж эхэлснээс үүдсэн байна. Тэрхүү амины тухай эртний монгол хүмүүнд шүтээн хэлбэрээр төсөөллийг бий болгосон анхны дохио нь “хүмүүн амь-байгал” загварын нь дагуу байгалаас бус харин өөрийн нь биеийн нууц “дүрс”-ээс үүссэн байдаг. Анхандаа тэр дүрс нь “этүгэн \онгод, эм\ дүрс” гэсэн “нэг” байсан. Тэгээд “бөө \тэнгэр, эр\ дүрс” нэмэгдэж “хоёр” болсон. Бүгд нийлээд “этүгэн бөө” хэмээх “гурав” болж эртний монголчуудын амь амьдралын “бэлх шүтээн”-ий хэлбэр үүсэж бүрэлдсэн (Т. Өлзий, 2011, х.63 -64).

Ертөнцийг мөн чанар болох “нэг” талын байгальчилагдсан хүн буюу “нэг бодгаль*” төсөөллөөсөө эртний монголчууд өөрсдийн амины талаар “тэнгэр” шүтээний хэлбэрээ үүсгэн хөгжүүлжээ. Нэг ертөнц болох “нэг бодгаль*”-ийн “хүмүүн-тэнгэр - газар” \”нэг-бодгаль*-нэг***\” төсөөллөөс, эртний монголчуудын ”амь” шүтээний “эцэг тэнгэр, эх дэлхий” болох “тэнгэр газар”-ын цогц бүрэлдсэн.

Мөн эртний монголчуудын хамаг бүхийг “нэг” –ээр буюу “нэг бодгаль*”-иар төсөөлөхүйгээс нь тэдний “амьдрал” шүтээний “амьтан” хийгээд “бодот хүн” хэлбэрүүд үүссэн байдаг. Жишээлбэл, өөрсдийн ертөнцийн талаарх “нэг бодгаль*”-ийн “амьдрал – байгаль -амьтан” \”нэг бодгаль* - нэг-бодгаль*\” төсөөллөөс, эртний монголчуудын ”амьдрал” шүтээний “бөртэ чоно, гоо марал” болох “амьтан” цогц бүрэлдсэн. Тэгээд эртний монголчуудын тэрхүү амьтан шүтээн нь яваандаа “бодот хаан ба хатан”-ы дүр болж хувирсан байдаг билээ

Энэ бүхнийг нэгтгэн үзвээс, эртний монголчуудын бөө мөргөлийн соёлын хийгээд гүн ухааны тулгуур ухагдахууны буюу генийн гурвал нь “амь – амьдрал – нэг” байна. Иймийн учир, эртний монголчуудын бөө мөргөл бол үе үеийн өвөг дээдсийн маань бүтээн хөгжүүлж, үр ач бидэндээ өвлүүлэн үлдээсэн амины, амьдралын, нэгийн тухай соёлын болон гүн ухааны генийг үүтгэн бүрдүүлсэн “өвөг” соёл, төдийгүй гүн ухаан хэмээж болно.

Монголчуудын соёлын генийн “амь-амьдрал-нэг” гурвалаас, түүний хос эхлэл нь “амь” ба “нэг”. Тэдгээрийн хоршин хоршин дэвжихүй бол “амьдрал”. Амь бол хос эхлэлийн “динамик”, “төрүүлэгч”, “хөдөлгөгч” тал. Нэг бол хос эхлэлийн “статик”, “бүтээгч”, “нөхцөлдүүлэгч” тал. Нэг \”нэг амь\” ба амь \”амь нэг\” нь хоёр

мөртөө нэгэн, нэгэн мөртөө хоёр бөгөөд харилцан бие, хэрэглэл болдог, харилцан бие биеэ өвөрлөсөн байдаг ухагдахуунууд. Динамик, төрүүлэгч, хөдөлгөгч тал болохынхоо хувьд “амь” нь монголчуудын соёлын генийн үүтгэл нэгэн эши ухагдахуун гэж хэлж болох байна.

Эртний монголчуудын “амь” ухагдахуун нь ерөнхийдөө өөрийнхөө “нэг” буюу билиг ухамсарлал талаасаа, тухайлбал, “онгод \этүгэн, эм\ дүрс”- ээс үүджээ. Түүнээс эсрэгцэл “тэнгэр \бөө, эр\ дүрс” – ийн ухамсарлал үүсэж, тэд нийлж нэгдэн арга билгийн ухамсарлал болох “этүгэн бөө” болж хөгжсөн нь “амь” ухагдахууны шүтээний хэлбэрийн нэгэн эхлэл юм. Амь ухагдахуун бол дүрсээс дүр, дүрээс бодот амьтан, бодот амьтнаас бодот хүн, бодот хүнээс хийсвэр ухагдахуун болж хөгжсөн. Жишээ нь, этүгэн бөө, алтан багана ба алтан сав, эцэг тэнгэр ба эх дэлхий, бөртө чоно ба гоо марал, бодот хаан ба бодот хатан” ...мөнх тэнгэр, “тэнгэр газар”, орон –цаг”, нэг бодгаль \бодгаль нэг\ ... ҮЙЛ зэрэг болно \1 дүгээр хүснэгт\.

Хүснэгт 1

АМЬ ухагдахууны үүсэл хөгжлийн нэгэн цуврал

Нэг	АМЬ	Амь
Онгод \этүгэн, эм, эм бэлх\ дүрс	Этүгэн бөө	Тэнгэр \бөө, эр, эр бэлх\ дүрс
Алтан сав	Бэлх шүтээн	Алтан багана
“.” – “цэг” нь эм бэлгэ тэмдэг	Тэнгэр шүтээн	“.” – “зураас” нь эр бэлгэ тэмдэг
Нум	Нум сум	Сум
Эх дэлхий	Хүн	Эцэг тэнгэр
Гоо марал	Батачихан	Бөртө чоно
Тэнгэр	Мөнх тэнгэр	Мөнх \цаг\
Газар	Тэнгэр газар	Тэнгэр
Орон	Орон - цаг	Цаг
Нэг	Нэг бодгаль, бодгаль нэг	Бодгаль
Үйл*	ҮЙЛ	Үйл

Дүгнэлт

Нүүдэлч Монголчуудын бөө мөргөлийн соёл, түүнээс улбаатай гүн ухааны эши ухагдахуун хийгээд бүтэж хөгжсөн арга технологи зэргийг орчин цагийн үйл судлалын харгалзах зүйлстэй харьцуулах замаар задлан шинжилж, нэгтгэснийхээ үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна:

- Монголчууд нэн эртнээсээ л байгал ба хүнийг, ахуй ба ухамсрыг, дүрс ба идийг далд ухамсрыг\, ёс ба эрдмийг, бэлгэ ба билгийг, шинж ба зөнг, тэмдэг ба ёрыг, дохио ба совинг, ад ба шидийг салгаж арга билгийн сэтгэлгээнд уяж байсан биш тэдгээрийн нэгсэл болох АМЬ ухагдахууныг дээдлэн шүтэж \тэдгээрийн учрыг АМЬ ухагдахуунд уяж, түүнийг шүүн шинжсээр\, түүнийг мөнх байлгахын болон аливааг үгээр нь бус үйлээр нь шинжихийн төлөө өөрсдийн бүхий үйл ажиллагаагаа чиглүүлсээр түүнийг танин мэдэж байсан юм.
- Эртний Монголчууд хүн байгалийн хувьслыг тэдгээрийн амин нэгдэлд нь авч үзэн, хүнийг байгальчлан \байгалийг хүнчлэн\ байгалийг бусөөрсдийгөө судлагдахуунаар сонгож, үүсэл хөгжлөө танин мэдэж, өөрсдийнхөө байгаль лугаа зохицон амьдрахуйн гүн ухаан, түүнээс улбаатай агуу түүх соёлыг бүтээн хөгжүүлсэн ард түмэн билээ. Тэрхүү амьдрахуйн гүн ухаан, агуу түүх соёлын гени нь өөрсдийн нээж олсон, хүн ба байгалийг холбогч буюу “зуучлагч” болох “амь” ухагдахуун болох нь

эдүгээ цагийн өндөрлөгөөс харагдаж байна.

- Нүүдэлч Монголчуудын бөө мөргөлийн гүн ухаан, ан агналын хийгээд мал малжлын соёлын нэгсэл нэгэн болох нүүдлийн соёлоос улбаатай “амь-ахуй-ухамсар”-ын гурамсан сэтгэлгээний “амь” ухагдахуун гэдэг бол “үйл” юм. “Амь” гэдгээс нь “үйл”-ийг монголчуудын уламжлалт соёлын гени хэмээж болно. Эсрэгээрээ, үйл гэдэг нь нүүдэл ч Монголчуудын бөө мөргөлийн сэтгэхүйгээс үүдэлтэй хүн ба орчны төгс зохицлыг зуучлагч монгол соёлын нь гени амь хэмээх ухагдахуун юм байна. Өөрөөр хэлбэл, ертөнцийг илэрхийлэгч хамгийн ерөнхий хийсвэр мөртөө хураангуй бодот ухагдахуун юм.
- Амь ухагдахууныг чухалчлан авч үзэж, өөрсдийн амьдрахуйн гүн ухааныг ан агнаж, мал маллаж байгальтай зохицон аж төрөн амьдрах үйлийн явцдаа суралцахуйнхаа буюу прагматик үйл судлалын ачаар бүтээжээ.
- Үйл судлал бол эртний монголчуудын гүн ухаан, агуу түүх соёлын эши үндэс буюу гени болох амины судалгаа байна. Иймд цаашид өөрсдийнхөө соёлын генийг үйлийн утгаар судлах нь монголчууд бидний язгуур суртахуун хийгээд түүх соёлоо дархлаажуулж, өвлүүлж хөгжүүлэхийн үндэс болно.

Ашигласан материал

- Өлзий, Тү. (2011). Эртний монголчуудын бөө мөргөлийн соёл сэтгэхүй. Улаанбаатар
- Нагаанбуу, Н. (2009). Итгэл зүйн ухаан – итгэлгүй нийгэм. Улаанбаатар
- Өлзий, Т. (2006). Эртний монголчуудын сэтгэхүйн хэв шинж, онцлог. Улаанбаатар
- Жадамба, Б. (2011). Үйлийн судалгааны квант онол. Улаанбаатар
- Монголын нууц товчоо, сонгомол эх, (2005). Улаанбаатар: Мөнхийн үсэг
- Нагаанбуу, Н. (2005). Монголчуудын амь, ахуй, ухамсарын гурвал онол. Улаанбаатар
- Доржи Банзаров, Банзаров Дорж, (1997). Собрание сочинений. 2-й дополнение. Издательство БНЦ, СОРАН. “Харын шашин буюу монголчуудын бөө мөргөлийн шашин”. Улан –Удэ
- Нагаанбуу, Н. (1999). Монгол гурвал онол. Улаанбаатар
- Баярсайхан, Б. (2009). Монгол хэлний хураангуй тайлбар толь. Улаанбаатар
- Монголын философийн түүх. (1995). Улаанбаатар
- Ган-Өлзий, Ч. (2001). Хүмүүнлэгийн гурван ертөнцийн гоц чанарыг судлахуйн чандмань эрдэнэ. Улаанбаатар
- Жадамбаа, Б. (2013) Лавай сэтгүүл. Улаанбаатар
- Kurt Lewin, (1946). Action Research in Minority Problems.
- Дулам, С. (1989). Монгол домог зүйн дүр, Улаанбаатар
- Хорлоо, П. (2002). Монгол аман зохиол дахь ардын гүн ухааны сэтгэлгээ, Өвөр монгол: Үндэсний хэвлэлийн хороо
- Вальтер Хейссиг, (1998). Монголын шашин суртахуун. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- Жадамбаа, Б. (2010). Монгол судлалын чуулган